



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 29 өдөр

Дугаар Б/87

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэнхэрмандал сумын Засаг дарга С.Золжаргал нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу хураан авсан чулууг дур мэдэн борлуулсан, хуулиар олгогдоогүй эрх эдэлж, хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Цэнхэрмандал сумын Засаг дарга С.Золжаргалд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА